

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/17

Арвайхээр

Албан тушаалын тодорхойлолт  
батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 5.1, Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолын 4 дэх, Төрийн албаны зөвлөлийн “Зөвшөөрөл олгох тухай” 2019 оны 198 дугаар тогтоолын 1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны даргын албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Орон нутгийн өмчийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Бараа, зөвлөх үйлчилгээний худалдан авалт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Хууль, эрх зүй, гэрээний хэрэгжилт, хөрөнгийн мэдээлэл лавлагаа, хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн программ хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, Санхүү, өмчийн хадгалалт, хамгаалалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Ажил худалдан авалт хариуцсан мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дээрх хавсралтаар батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг төрийн захиргааны албан хаагчдад танилцуулан, хувийн хэрэгт хийж ажиллахыг Хууль, эрх зүй, гэрээний хэрэгжилт, хөрөнгийн мэдээлэл лавлагаа, хөрөнгийн бүртгэл мэдээллийн нэгдсэн программ хариуцсан мэргэжилтэн (А.Баяндүүрэн)-д даалгасугай.



Н.ГАНБОЛД

177110031